



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 5/07

Мандалговь

Лувсанданзаны Уртнасанг
ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Газрын дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын үйлчлэгч, зарлагын ажилд Лувсанданзаны Уртнасанг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

2.Л.Уртнасангийн албан тушаалын үндсэн цалинг ТҮ-1 буюу 900,000 (есөн зуун мянга) төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар, хоолны үнийн хөнгөлөлтийг өдрийн 8,000 (найман мянга) төгрөгөөр тооцож олгохыг ерөнхий нягтлан бодогч (А.Нэргүй)-д зөвшөөрсүгэй.

3.Үйлчлэгч, зарлага Л.Уртнасангийн ажил үүргийн хуваарь, байгууллагын дүрэм, журам, холбогдох бичиг баримтуудтай танилцуулан, хувийн хэргийг нь бүрдүүлэн авч, хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн (Б.Батхүү)-д даалгасугай.

4.Холбогдох хууль, тогтоомж, газрын дүрэм, журмуудыг чанд сахин, идэвх зүтгэл гарган хариуцсан ажлаа чанартай гүйцэтгэж ажиллахыг үйлчлэгч, зарлага (Л.Уртнасан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ГАНТУЛГА

Tushaal B.docx

482401039